



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 01

Шарга

**ИТХ, Тэргүүлэгчдийн ажлын тайлан хэлэлцэх,
2015 оны ажлын төлөвлөгөө батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, Нутаг дэвсгэрийн нэгж, Түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 /в/, 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ИТХ-ын ээлжит IX хуралдаанаас ТОГТООХ нь:

1. 2014 оны ИТХ, Тэргүүлэгчдийн жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт үр дүнг хангалттай гэж дүгнэсүгэй.

2. ИТХ, Тэргүүлэгчдийн 2015 оны жилийн ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчид, ИТХ-ын нарийн бичгийн дарга Л.Сэрсмаа нарт үүрэг болгосугай.

ДАРГА  М.АЗБАЯР



ЦАГААН-УУЛ СУМЫН ИТХ, ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2015 ОНД
ХИЙХ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2015-03-02

№	Хийх ажлын утга	Хугацаа	Хариуцаж гүйцэтгэх байгууллага, албан тушаалтан	Хэрэгжүүлэх арга зам, үр дүн
1. Иргэдийн төлөөлөгчдийн жилийн хийх ажлын төлөвлөгөө, хурлаар хэлэлцэх асуудлууд				
1	Тэргүүлэгчдийн ажлын тайлан, тогтоол шийдвэрийн биелэлтийг хэлэлцэх, жилийн ажлын төлөвлөгөөг батлах	1 дүгээр улиралд	Иргэдийн хурлын дарга, тэргүүлэгчид	Ажлын тайланг дүгнэж төлөвлөгөөг баталж тогтоол гарна.
2	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт өгөх	1 дүрээр улиралд	Сумын Засаг дарга, ажлын хэсэг	Ажлын биелэлтийг дүгнэж үүрэг чиглэл өгч тогтоол гарна.
3	Нутаг бэлчээр ашиглах журмын хэрэгжилт үр дүн	1 –р улирал	Сумын засаг дарга	Журмын биелэлтэнд дүгнэлт өгч, үүрэг чиглэл өгнө
4	Нохой эзэмших, золбин нохой устгах журмын хэрэгжилт, үр дүн	1-р улирал	Сумын засаг дарга	Журмын хэрэгжилтэнд тогтоолоор дүгнэлт өгч, үүрэг чиглэл өгнө.
5	Байгаль орчны тасгийн 2014 оны жилийн ажлын тайлан, Байгаль хамгаалах сангийн зарцуулалтыг хэлэлцэж батлах	1-р улирал	Сумын засаг дарга, Байгаль орчны тасаг	Тогтоолоор дүгнэж, үүрэг чиглэл өгнө
6	Хил хамгаалах орон тооны бус зөвлөлийн жилийн ажлын тайлантай танилцаж, зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж шинэчлэх	1-р улирал	Хил хамгаалах орон тооны бус зөвлөлийн дарга Д.Түмэнбаяр	Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилэн баталж, үүрэг чиглэл өгнө.
7	2015 оныг "Хүний хөгжлийг дэмжих жил" хүрээнд хийсэн ажлын тайлан.	1 дүгээр улиралд	Хурлын дарга, Сумын засаг дарга	Хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг боловсруулж батална.
8	2014 оны орон нутгийн орлогын биелэлт, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж тодотгол хийх	1 дүгээр улиралд	Төрийн сангийн төлөөлөгч, нягтлан бодогч, татварын байцаагч	Тодотгол хийж давсан орлого зарцуулах тухай тогтоол гарна.
9	2015 онд ойгоос бэлтгэх хэрэглээ, түлшний модны дээд хязгаар батлах	1-р улирал	Засаг дарга Д.Түмэнбаяр	Тогтоолоор батална.
10	Дэлгэр мөрний сав газрыг Орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай	1-р улирал	Засаг дарга Д.Түмэнбаяр	Тогтоолоор батална
11	Галт дулаан ОНӨААТҮГ-ын жилийн санхүү, үр дүнгийн тайланг хэлэлцэх	1 дүгээр улиралд	ИТХ-ын дарга Ч.Азбаяр Галт дулаан ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогч	Үүрэг даалгавар өгөх, байгууллагын дүрмийн дагуу ашгийг хуваарилж батлах
12	Гурван буман малын баяр болон Сум дундын эмнэлгийн 80 жилийн ойн	1-р улиралд	Засаг дарга Д.Түмэнбаяр	Тогтоолоор баярын тов, зохион байгуулах хорооны

	баярын тов, баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг томилох			бүрэлдэхүүнийг батална
13	2015 оны төсвийн гүйцэтгэл, орон нутгийн орлогын хагас жилийн тайланг хэлэлцэх	3 дугаар улирал	ЗДТГ-ын дарга, төрийн сангийн төлөөлөгч, нягтлан бодогч, татварын байцаагч, ИТХ-ын хороод	Үүрэг чиглэл, үнэлгээ өгнө.
14	Орон нутгийн хөжлийн сангийн зарцуулалт, явцын ажлын үр дүн, гүйцэтгэл	3 дугаар улирал	Сумын засаг дарга, ЗДТГ-ын дарга	Хэрэгжилт, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгнө.
15	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн хагас жилийн ажлын тайланг хэлэлцэх	3 дугаар улирал	Сумын засаг дарга, БОТХБТ-ийн дарга	Үнэлгээ, үүрэг чиглэл өгнө.
16	Ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүдтэй хийсэн гэрээний биелэлт, үр дүн	3 дугаар улирал	Сумын засаг дарга, ИТХ-ын хороод	Үүрэг чиглэл, үнэлгээ дүгнэлт хийнэ.
17	Сум хөгжүүлэх хөрөнгийн зээлийн олголт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн	3 дугаар улирал	Хяналт шалгалтын ажлын хэсэг, ИТХ-ын хороод	Зээлийн олголт, төслийн хэрэгжилтэнд дүгнэлт, үүрэг даалгавар өгнө.
18	2015 оны орон нутгийн орлогын төлөвлөгөө, төсвийн төсөл	2015 оны 12 сарын эхний 7 хоног	Сумын Засаг дарга, Төсвийн менежрүүд	Тогтоол гарна.
19	Орон нутгийн хөгжлийн сан, тусгай сангуудаар хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэлэлцэх	2015 оны 12 сарын эхний 7 хоног	Сумын засаг дарга, ЗДТГ, ажлын хэсэг, ИТХ-ын хороод	Төсвийн төсөлтэй хавсралтаар батлагдана.
20	2014 оны үндсэн чиглэл /хөрөнгө оруулалтын арга хэмжээ/-ний биелэлт, 2015 оны үндсэн чиглэл	12 сарын эхний 7 хоног	Сумын засаг дарга, Ажлын хэсэг	Төсвийн төсөлтэй хавсралтаар батална.
21	Төсвийн захирагч нарын . 2014 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, 2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ	12 сарын эхний 7 хоног	Төсвийн Ерөнхийлөн захирагч нар, төсвийн менежрүүд, ИТХ-ын хороод	Хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлэлт өгсөн тогтоол гарна. Хөтөлбөрийг төсвийн төсөлд хавсралтаар батална.
22	Тэргүүлэгчдийн жилийн ажлын тайлан дүгнэж ИТХ, Тэргүүлэгчдийн 2015 оны ажлын төлөвлөгөөг батлах	12 сарын эхний 7 хоног	Иргэдийн хурлын дарга, ажлын алба, ИТХ-ын хороод	Ажлын тайланд үнэлгээ өгч төлөвлөгөөг тогтоолоор батална.
23	ОНӨААТҮГ-уудын 2015 оны үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөг батлах	12 сарын эхний 7 хоног	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогч	Санхүүгийн зөв зарцуулалт, ханалт сайжирна.
24	Бусад /төлөвлөгдөөгүй гарч ирсэн асуудал/	Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлана.	Холбогдох мэргэжилтэн албан тушаалтан	Ээлжит болон ээлжит бус хурлын хэлэлцэх асуудалд тусган шийдвэр гаргасан байх
1	Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж иргэдэд хууль сурталчлах ажил зохион байгуулах	1 дүгээр сард	Тэргүүлэгчид, ажлын алба	Ажлыг чанартай зохион байгуулж гүйцэтгэлийн тайланг гаргана.
2	Залуу өсвөр үеийнхний дунд илтгэл, эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулах	1 дүгээр сард	Тэргүүлэгчид, ажлын алба	Ажлыг чанартай зохион байгуулж гүйцэтгэлийн тайланг гаргана.
3	Эмэгтэйчүүдийн чуулга уулзалт зохион байгуулах	3-р сард	Эмэгтэй төлөөлөгчид, ИТХ-ын нарийн бичгийн дарга	Ажлыг чанартай зохион байгуулж гүйцэтгэлийн тайланг гаргана.

4	Залуусын хөгжлийг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулж байгаа Залуу төлчдийн зөвлөгөөнийг ЗДТГ-тай хамтран зохион байгуулж НӨУЕБ-ын эрх үүргийн талаар ойлголт өгч илтгэл тавина	3-р сард	ИТХ-ын дарга, төлөөлөгчид, ажлын алба	Уриалгын төсөлд БИНХ-д идэвхи санаачлагатай оролцох талаар асуудал тусгуулах, оролцсон залууст БИНХ-ын эрх үүргийн талаар эмхэтгэл тараасан байх
5	Төрийн одон медаль, шагналд тодорхойлох, дээд шатны байгууллагад уламжлах	1, 5, 11 сард	Багийн засаг дарга, БИНХ, Тэргүүлэгчид, ажлын алба	Багийн засаг дарга, БИНХ-ын тогтоол шийдвэр, тэмдэглэлийг үндэслэн дээд шатны байгууллагад тогтоолоор дэмжиж уламжлах
6	Алдарт эхийн одонгийн болзол хангасан эхчүүдийг тодорхойлж дээд шатны байгууллагад уламжлах	3 дугаар сард	НХБ, Тэргүүлэгчид, ажлын алба	НХБ-ын бүрдүүлсэн материалыг үндэслэн тогтоолоор дэмжиж уламжлах
7	БИНХ-ийн жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах	3 дугаар сард	Тэргүүлэгчид, ажлын алба, БИНХ-ын дарга нар	БИНХ-ын үйл ажиллагаа жигдэрнэ.
8	Олон улсын Цусны донорын өдрийг тохиолдуулан донорууддаа хүндэтгэл үзүүлж, донорын ач тусыг олон нийтэд сурталчлах, донорын эгнээг нэмэгдүүлэх	6-р сар	ИТХ-ын ажлын алба, Төлөөлөгчид Эмнэлгийн нийгмийн ажилтан	Доноруудын танилцуулга бүхий хүндэт самбар гарсан байх, донорын тоог нэмэгдүүлсэн байх.
9	Улаан загалмайн үйл ажиллагааг сурталчлан таниулах өдөрлөг зохион байгуулж, улаан загалмайн гишүүдийн дунд уралдаан тэмцээн зохион байгуулна	11-р сард	Тэргүүлэгчид, ажлын алба	Улаан загалмайн татварыг төвлөрүүлж, улаан загалмайн гишүүдийн тоог нэмэгдүүлсэн байх
10	Эрүүл сум, баг, ажлын байр, сургууль бий болгох сумын дэд хөтөлбөрийн биелэлт, үр дүн	4-р сар	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн дарга Д.Түмэнбаяр	Тогтоолоор дүгнэж, үүрэг чиглэл өгнө.
11	Соёлын төвийг УГЗ Н.Ганхуягийн нэрэмжит болгох тухай	4 дүгээр сард	Соёлын төвийн захирал Н.Дашдаваа	Тогтоолоор баталж нэрэмжит болгон зарлана
12	Баг бүрт иргэдийн хурлын нээлттэй хаалганы өдөрлөгийг багийн төвүүдэд зохион байгуулах.	3, 6, 9, 10 сард	Төлөөлөгчид, ажлын алба	Сургалтыг чанартай зохион байгуулж үр дүн гүйцэтгэлийг тооцох
13	Залуусын хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Санхүү, эдийн засаг, хөрөнгийн бирж, хувьцааны талаархи ойлголт, мэдлэг олгох сургалт зохион байгуулна/ Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеээр/.	3, 6, 9, 10 сард	ИТХ-ын дарга, төлөөлөгчид	Сургалтыг чанартай зохион байгуулж үр дүн гүйцэтгэлийг тооцох.
14	Залуусын хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Орон нутгийн хөгжилд залуусын оролцоо сумын залуучуудын чуулган зохион байгуулна.	8-р сард	ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, ЗДТГ	Зөвлөгөөнийг чанартай зохион байгуулж, уриалгын төсөл батлах
15	Байгууллагуудын актлах хөрөнгийн материалыг хүлээн авч хэлэлцэх.	6, 12 сард	Төсвийн менежрүүд, Тэргүүлэгчид	Тогтоол гарна.

16	Төсвийн байгууллагуудын Хагас, бүтэн жилийн аждыг тайланг хэлэлцэх	6, 12-р сард	Төсвийн менежрүүд	Тогтоолоор дүгнэж, үүрэг чиглэл өгнө.
17	ЖДҮ-ийн зээлийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хэсгийн тайлан илтгэлийг хэлэлцэх шийдвэрлэх	6, 9, 11 дүгээр саруудад	Тэргүүлэгчид, ажлын алба, ИТХ-н хороод	Үнэлгээ дүгнэлт өгч тогтоол гарна
18	ГХУСАЗСЗ-ийн ажлын тайланг хэлэлцэнэ.	6, 11-р сар	Тэргүүлэгчид, ажлын алба, цагдаагийн хэсэг, нийгмийн ажилтан	Тогтоол гаргаж сар бүрийн сүүлээр ажлын үр дүн, төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэнэ.
19	Суманд мэдээллийн ил тод байдлыг хангах журамын хэрэгжилт, үр дүн	6-р сард	Сумын Засаг дарга, Төсвийн менежрүүд	Журмын хэрэгжилтэнд дүгнэлт өгч, зөвлөмж чиглэл өгнө.
20	Хүүхдийн цэцэрлэгийн 2014-2016 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, үр дүн	6-р сард	Цэцэрлэгийн эрхлэгч	Тогтоолоор дүгнэлт өгч, үүрэг чиглэл өгнө.
21	Хүүхдэд ээлтэй сум 2014-2016 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн	11-р сар	Сумын Засаг дарга Д.Түмэнбаяр	Тогтоолоор дүгнэлт өгч, үүрэг чиглэл өгнө.
22	Хүүхэд хамгааллын бодлого журмыг боловсруулж хэрэгжүүлэх	5-р сар	Хүүхдийн зөвлөл, нийгмийн ажилчид, Тэргүүлэгчид	Хөтөлбөр, журам боловсруулан тогтоолоор баталсан байх.
23	Ерөнхий бовсролын сургуулийн 2014 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 7 дугаар тогтоолоор батлагдсан Сургууль хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн	4-р сар	Сургуулийн захирал, менежер	Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг үнэлж тогтоол гарна.
24	ЕББДС-ийн сурагчдын дунд архи, тамхины хор хөнөөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, ухуулгын ажил зохион байгуулах	5, 9 дүгээр сард	ГХУСАЗСЗ, Сургуулийн нийгмийн ажилтан, ажлын алба	Сургалт, ухуулгын ажлыг чанартай зохион байгуулж үр дүн гүйцэтгэлийг тооцох
25	Төсөв санхүүгийн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавьж зарцуулалт, үр дүнг олон нийтэд мэдээллэх	6, 10 дугаар сар	Тэргүүлэгчид, ажлын алба, ИТХ-ын хороод	Заавар чиглэл өгч дүгнэлт гарган олон нийтэд мэдээллэнэ.
26	Төлөөлөгч бүрийг тойрогтоо ажиллахад нь дэмжлэг үзүүлж удирдамж, чиглэлээр хангах	6, 8 дүгээр саруудад	Тэргүүлэгчид, ажлын алба	Төлөөлөгч бүрийн тойрогтоо ажилласан тайланг гаргуулж бодлого шийдвэртээ тусгах
27	Төлөөлөгчдийг ИТХ, Тэргүүлэгчдийн гаргасан шийдвэрийн эмхтгэлээр хангах	7, 12 дугаар сар	Тэргүүлэгчид, ажлын алба	Ном хэлбэрээр хэвлүүлж тараана.
28	Багийн ИНХ-ын журам боловсруулж батлуулах	4 дүгээр сард	Тэргүүлэгчид, олон нийтийн хэлэлцүүлэг	Тогтоолоор журам баталж мөрдүүлнэ.
29	Хог хаягдлыг зохицуулах журманд өөрчлөлт оруулах	3 дугаар сард	6-р багийн засаг дарга, Гал дулаан ОНӨААТҮГ,	Тогтоолоор баталж мөрдүүлнэ.

			Тэргүүлэгчид	
30	Сумын журам боловсруулах	6 дугаар сард	Сумыг Засаг дарга, Хурлын төлөөлөгчид, БИНХ-ын дарга	Тогтоолоор баталж мөрдүүлнэ.
31	Иргэний танхимын журам боловсруулах, хурлын дэргэд иргэний танхимтай болох	5 дугаар сард	Хурлын төлөөлөгчид	Тогтоолоор баталж ИТХурлын ажлын албаны орон тоог нэмэгдүүлнэ.
32	Бусад /төлөвлөгөөнд ороогүй асуудал/	Тухай бүр нь тэргүүлэгчдээр хэлэлцэн шийдвэрлэнэ.	Хурлын ажлын алба, тэргүүлэгчид	Асуудлыг судлан ИТХ, тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх

— оОо —